

2020 ЖИЛИЙН ТАЙЛАН



АГУУЛГА

ТУЗ-ын даргын мэндчилгээ	2
Эрхэм зорилго	3
Гүйцэтгэх захирлын мэндчилгээ	4
Компанийн танилцуулга	5
Санхүүгийн үзүүлэлтүүд	6
2020 оны онцлох үйл явдлууд	7
Байгууллагын даатгал	8
Давхар даатгал	9
Иргэдийн даатгал	10
Эрсдэлийн удирдлага	12
Нөхөн төлбөрийн үйл ажиллагаа	13
Даатгалын зах зээлийн мэдээлэл	14
Нийгмийн хариуцлага	15
Удирдлагын баг	16
Хувьцаа эзэмшигчид	18
Хянан нийцүүлэх үйл ажиллагаа	19
Төлөөлөн удирдах зөвлөл	20
Хараат бус аудиторын тайлан	22

ТУЗ-ЫН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, харилцагчид, түншүүд ээ,

Тэнгэр Даатгал компанид итгэл хүлээлгэн урт удаан хугацааны турш хамтран ажиллаж ирсэн харилцагч, түнш байгууллагууд, та бүхэнд талархал илэрхийлье. Энэ жил Тэнгэр Даатгал компанийн 20 жилийн ой тохиож байгааг дуулгахад таатай байна. Монгол улсын даатгалын салбарт 2001 онд Бат Даатгал нэртэйгээр мөрөө гарган эхэлсэн компани өдгөө 26 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй 90 гаруй ажилтантай, Монгол улс даяар 21 салбартай, тэргүүлэгч даатгалын компаниудын нэг болсон байна.

Хэдийгээр өнгөрсөн жилийн хувьд бизнесийн салбарт амаргүй жил байсан ч Тэнгэр Даатгал компанийн цэвэр ашгийн хэмжээгээ өсгөж 1.6 тэрбумд хүргэсэн нь цар тахлын үед авч хэрэгжүүлсэн компанийн зөв бодлого, нийт ажиллагсдын хичээл зүтгэлийн үр дүн юм. Тэнгэр санхүүгийн нэгдлийн 2020 онд тавьсан зорилтуудын нэг цахим шилжилтийн ажлын хүрээнд Тэнгэр Даатгал компани Даатгалын цогц аппликейшнийг зах зээлд амжилттай нэвтрүүлээд байна.

Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай орнуудын жагсаалт буюу “саарал жагсаалт”-аас гаргах Монгол улсын засгийн газраас байгуулсан ажлын хэсэгт Тэнгэр Даатгал компани даатгалын салбарыг төлөөлөн орж ажилласан бөгөөд 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар Монгол улсыг энэхүү жагсаалтаас гаргахаар шийдвэрлэсэн билээ.

Компанийн шинэ стратегийн зорилтуудыг биелүүлэх гол тулгуур бол удирдлагын баг, хамтран ажиллагсад билээ. Бид Тэнгэр Даатгалын эрч хүчтэй, чин эрмэлзэлтэй баг хамт олонгүйгээр 2020 оны үр дүнд хүрэх боломжгүй байлаа. Мэргэжлийн өндөр ёс зүй, ур чадвартай, шилжилтийн амаргүй үед биднийг дэмжиж ажилласан нийт ажиллагсдадаа гүн талархал илэрхийлмээр байна.


Бид аж ахуйн нэгж, байгууллагууд, иргэд харилцагчдын өдөр тутмын амьдрал, хүрээлэн буй орчинд учирч буй эрсдэлүүдийг бодитойгоор тооцох, түүнийг удирдах шинэлэг арга аргачлалыг бий болгох дотоод бүтэц тогтолцоог бий болгон Монгол Улсын эдийн засаг түүний дотор даатгалын салбарын хөгжилд өөрийн өнгө аяс, дуу хоолойгоор хүч нэмж, даатгалын компанийн засаглалын тэргүүн туршлагуудыг нэвтрүүлж манлайлагч байгууллагын байр сууриа цаашид бэхжүүлэхийн тулд хичээн ажиллах болно.

Хүндэтгэсэн,

Г.Цэвэгжав

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга

ЭРХЭМ ЗОРИЛГО



ХЭТИЙН ЗОРИЛТ

Бид Монголдоо дэлхийн түвшний санхүүгийн үйлчилгээтэй байгууллага болно.



ЭРХЭМ ЗОРИЛГО

Эрдэнэт хүмүүн, Эх дэлхий, Эрүүл ашгийг эрхэмлэн харилцагчиддаа үнэ цэнэтэй санхүүгийн үйлчилгээг хүргэж, насан туршийн түнш нь байх болно.



ҮНЭТ ЗҮЙЛС

Бид хэтийн зорилт, эрхэм зорилгодоо хүрэхийн тулд дараах зүйлсийг өдөр тутмын үйл ажиллагаандаа эрхэмлэн ажиллана. Үүнд:



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



ЭРХЭМ ХҮНДЭТ ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧИД, ХАРИЛЦАГЧИД,
ТҮНШҮҮД ЭЭ,

Тэнгэр Даатгал ХХК-ийн 2020 оны жилийн тайлантай танилцаж буй эрхэм харилцагчид, хамтран ажиллагчид, давхар даатгагчид болон төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийнхээ амар мэндийг эрэн мэндчилье. Та бүхний байнгын дэмжлэг, хамтын ажиллагаанд гүнээ талархаж байгаагаа илэрхийлье.

Тэнгэр Даатгал компани нь олон улсын нэр хүнд бүхий хөндлөнгийн Аудитын компаниар санхүүгийн тайлангаа жил бүр хянан баталгаажуулалт хийлгэж үйл ажиллагааныхаа чанарт байнга анхаарч ирсэн билээ. Ийм ч учраас Чанарын олон улсын стандарт болон зохицуулагч байгууллагаас тавигддаг зохистой харьцааны үзүүлэлтүүдийг тогтмол ханган ажиллаж байна. Сүүлийн 2 жилийн хугацаанд дэлхий нийтээрээ цар тахалтай нүүр тулан хүндхэн сорилтыг хамтдаа туулж байна. Энэ саад бэрхшээлийг зүгээр хараад суулгүйгээр боломж болгон ашиглан, өөрчлөлтийг цаг алдалгүй хүлээн авч дижитал шилжилтийг дотоод үйл ажиллагаа болон харилцагчийн үйлчилгээнд нэвтрүүлэх ажил өнөөдөр амжилттай хэрэгжиж байна. Үүний томоохон жишээ бол бидний 10 сард зах зээлд нэвтрүүлсэн даатгалын аппликейшн өдгөө 17,000 гаруй харилцагчидтай болоод байна. 2018 онд анхны веб суурьтай онлайн даатгалын систем хөгжүүлж байсан даатгалын үйлчилгээ эдүгээ ухаалаг гар утаснаасаа хүссэн үедээ хаанаас ч үйлчилгээ авах боломжийг бүрдүүлсэн даатгалын цогц аппликейшн болон шинэчлэгдлээ. Мөн бизнесийн бусад салбарын цахим гарцуудыг дэмжиж, тэдэнтэй үйл ажиллагаагаа нэгтгэх зорилгоор MonPay, Storepay, Qpay болон Insur зэрэг аппликейшнуудтай хамтран ажиллаж эхлээд байна.

Тайлант хугацаанд бид нийт 70000 гаруй харилцагчид даатгалын үйлчилгээ үзүүлж нийт 16.2 тэрбум төгрөгийн хураамжийн орлогийг төвлөрүүлэн, цэвэр ашиг өмнөх оноос 1 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Өнгөрсөн онд нөхөн төлбөрийн үйлчилгээг сайжруулах ажлын хүрээнд материалыг онлайнгаар хүлээн авах ажлыг эхлүүлэн нийт 4.8 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг харилцагч байгууллага, иргэдэд түргэн шуурхай олгосон байна.

Тэнгэр Даатгал нь дэлхийд тэргүүлэгч давхар даатгагчидтай хамтран ажилласнаар эрсдэл даах чадвараа жил ирэх тусам нэмэгдүүлсээр ирлээ. Бид дэлхийн тэргүүлэгч даатгалын компани болох AIG компанитай хамтран байгууллагуудад учирч болох томоохон эрсдэлүүд дээр үнэлгээ хийн, шилдэг туршлагыг дотооддоо нэвтрүүлэн ажиллаж байна.

2021 онд Тэнгэр Даатгал компанийн 20 жилийн ой тохиож байна. Тэртээ 2001 онд байгуулагдсан цагаас эхлэн компанийн өнөөгийн хүрсэн амжилтад үнэтэй хувь нэмэр оруулж байгаа нийт харилцагчид, хамтран ажиллагчид, бизнесийн түншүүд та бүхэндээ талархал илэрхийлэхийн зэрэгцээ аливаа учирч болзошгүй эрсдэл, хүндрэл бэрхшээлийг хамтдаа даван туулахын төлөө хичээн ажиллахаа Тэнгэр Даатгал компанийн нийт ажиллагчдын өмнөөс илэрхийлж байна.

Хүндэтгэсэн,
Ж.Мөнхсайхан
Гүйцэтгэх захирал

КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА



Тэнгэр Даатгал компани нь 2001 онд байгуулагдсан бөгөөд өдгөө Тэнгэр Санхүүгийн Нэгдлийн 100% хөрөнгө оруулалттайгаар 20 дахь жилдээ тогтвортой үйл ажиллагаа явуулж байна. Бид харилцагчийн эрсдэлийн удирдлагын цогц шийдлийг санал болгон ажилладаг харилцагчдын итгэл найдварыг бүрэн хүлээсэн даатгалын салбарын тэргүүлэгч компани юм.

Бид санхүүгийн ил тод үйл ажиллагаатай, нийгмийн хариуцлага, хамтын ажиллагааны цар хүрээ, сайн засаглалыг баримтлагч зэргээрээ Монголын даатгалын зах зээлд тэргүүлсээр байх болно.

Тэнгэр Даатгал компани Монгол Улс даяар өөрийн 19 салбар, 124 төлөөлөгч, 33 зуучлагч компани болон 8 банк, мөн өөрийн цахим сувгуудаар дамжуулан иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад адил хүртээмжтэй байдлаар даатгалын үйлчилгээг хүргэснээр 68,000 гаруй иргэн, 2000 гаруй байгууллагын эрсдэлийг шилжүүлэн авч байгаа нь зах зээлийнхээ 10 орчим хувийг бүрдүүлж байна.

Байгуулагдсан
ОН



2001

Салбар



19

Ажилтан



90

Төлөөлөгч




128


САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД




/Сая.төг/




Нийт хураамж




Нийт хөрөнгө




Цэвэр ашиг



Эздийн өмч



Нөөц сан



Цэвэр нөхөн төлбөрийн зардал

12,114,738

11,019,336

2020 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

#АЖИЛЛАХ ТАВ ТУХ



Компанийн төв оффисыг шинээр засч тохижуулан ажиллагсдын ажиллах тав тухыг хангасан орчин үеийн шийдлүүдийг багтаасан шинэ оффистой боллоо.

Ажилтнуудын идэвхи санаачлагыг дэмжиж, манлайлах чадвараа хөгжүүлэх ажлын хүрээнд ментор хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлж салбартаа тэргүүлэгч, манлайлагчдаас зөвлөгөө авч эзэмшсэн мэдлэг чадвараа практик дээр ашиглах боломжийг олгосон.



#ЧАДВАРЛАГ БАГ

#АРГА ХЭМЖЭЭ



Үл хөдлөх хөрөнгийн салбарт бизнес эрхлэгчид, оролцогчид, сонирхогчдыг нэг дор цуглуулсан One Solution event /TEDxUlaanbaatarSalon/ арга хэмжээнд ерөнхий ивээн тэтгэгчээр оролцлоо

Хэзээ ч хаанаас ч хүссэн үедээ даатгалын үйлчилгээ авах боломжийг харилцагчид олгосон Даатгалын цогц шийдэл бүхий Edaatgal аппликейшнийг танилцууллаа.



#ЦАХИМ ДААТГАЛ

БАЙГУУЛЛАГЫН ДААТГАЛ




Тэнгэр Даатгал ХХК-ийн 2020 онд салбар бүрийн хувийн болон төрийн өмчит байгууллага, аж ахуй нэгжүүд түүний ажиллагсдад даатгалын цогц үйлчилгээг үзүүлэн нийт 9 их наяд төгрөгийн үнэлгээ бүхий эрсдэлийг шилжүүлэн авч ажилласан байна.


Бид хамтран ажиллагч байгууллага, харилцагчиддаа тоон үзүүлэлтээс илүүтэйгээр үнэ цэнэ нэмэх мэргэжлийн төвшний үйлчилгээг үзүүлэх, даатгалын ач тусыг таниулах, учирч болох эрсдэл болон түүнээс урьдчилан сэргийлэх зөвлөгөө үйлчилгээг тогтмол хүргэн ажилласнаар харилцагчийн сэтгэл ханамжийг өсгөсөн амжилттайгаар ажиллажээ. Энэ хүрээнд харилцагч байгууллагын үйл ажиллагааны онцлогоос хамааран оновчтой даатгалын үйлчилгээг санал болгох, галын болон хөдөлмөрийн аюулгүй байдлын талаар тусгай мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж, харилцагч байгууллагад учирч болох эрсдэлийн үнэлгээг хийлгэх, урьдчилан сэргийлэх зөвлөмж бэлтгэн хүргүүлэн ажилласнаар харилцагч байгууллагуудад санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлээ бууруулан ажиллахад нь хувь нэмрээ оруулан ажиллалаа.

2020 он Дэлхий нийтээрээ цар тахалтай нүүр тулсан, санхүүгийн хувьд хүндхэн жил болж өнгөрсөн. Бидний зүгээс Байгууллагын даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг харилцагчдад улам ойртуулах, харилцагчдаа эрсдэлээс сэргийлэх ажлуудыг тогтмол зохион байгуулж ажилласнаар харилцагч байгууллагууддаа 741.5 хүн цагийн сургалтыг зохион байгуулж, томоохон арга хэмжээнүүдэд хамтран оролцож даатгалын үйлчилгээг таниулснаар нийт харилцагчид маань цар тахлаас үүссэн эдийн засгийн хямрал үүссэн энэ хүнд үед эрсдэлээ бидэнд даатган хамтран ажилласан нь манай байгууллагын хувьд харилцагчиддаа эрсдэлийн удирдлагын зөвлөгөөг зөв цагт, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хүргэж байсны үр дүн гэж харж байна.

Шилжүүлэн авсан эрсдэл



Даатгуулсан байгууллагын тоо



ДАВХАР ДААТГАЛ



Тэнгэр Даатгал ХХК-ийн давхар даатгалын үйл ажиллагаа нь компанийн багцын эрсдэлийг удирдах Трити давхар даатгалын хамгаалалт, харилцагчийн тухайлсан эрсдэл болон шаардлагад нийцүүлсэн факультатив давхар даатгал болон фронтинг давхар даатгал хэлбэрээр хэрэгждэг.

Бид даатгалын зах зээл дээрх хамгийн өндөр хамгаалалт болох 12.5 сая долларын үнэлгээ бүхий Трити буюу багцын давхар даатгалын хамгаалалттай бөгөөд Хөрөнгийн даатгал, Барилга угсралтын даатгал, Ачаа тээврийн даатгал, Хариуцлагын даатгал, Гэнэтийн ослын даатгал, Тусгай зориулалтын машин механизм, хүнд даацын тээврийн хэрэгслийн даатгалуудаар хүлээн авсан эрсдэл шууд давхар даатгалын хамгаалалтад ордог.

Компани нь санхүүгийн зэрэглэлийн үнэлгээгээр A.M.Best “A-”-ээс дээш үнэлгээтэй нэр хүнд бүхий зах зээлд тэргүүлэгч давхар даатгалын компаниудтай хамтран ажилладаг. Тухайлбал: SCOR Perestrakhovaniye, “Chubb”, Forbes сэтгүүлийн 500 компанийн дийлэнхийг даатгагч “American International Group /AIG/”, PICC Property and Casualty Insurance Co., Ltd, If P&C Insurance Ltd, SIRIUS давхар даатгалын компани г.м.

2021 онд бид давхар даатгалын өргөн хүрээтэй хамтын ажиллагаа хөгжүүлэхийн зэрэгцээ даатгалын салбарт олон шинэ боломжуудыг нээхээр төлөвлөж байна.



ИРГЭДИЙН ДААТГАЛ



МОНГОЛ ОРОН ДАЯАР

Тэнгэр Даатгал ХХК нь орон нутагт 19 салбарын ажилтнууд болон даатгалын төлөөлөгчдөөр дамжуулан 2020 онд дараах зорилго, зорилт тавьж ажилласан.

- Салбарын үр ашгийг сайжруулах;
- Төр, хувийн хэвшлийн байгууллагатай харилцан ашигтай хамтын ажиллагааг бэхжүүлэх;
- Ажилтны мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх замаар урт хугацаанд тогтвортой хүний нөөцтэй байх;

Хэдийгээр 2020 онд Ковид19 цар тахлын улмаас улс орны эдийн засгийн нөхцөл байдал таатай байгаагүй ч бид орон нутгийн иргэд, байгууллагад даатгалын талаарх сургалт, өдөрлөг, аян зохион байгуулж, даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлан ажилласны үр дүнд харилцагчдын тоог өмнөх оноос 10%-р өсгөж чадлаа. Үүнээс даатгуулагч иргэдийн тоо 14%-р нэмэгдэж, байгууллагын тоо 2%-р буурсан үзүүлэлттэй байна. Харин иргэд болон байгууллагын төлсөн даатгалын хураамжийн харьцаа 50/50 хувийг эзэлж байна.

Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд Ковид19 цар тахлын аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор харилцагчдадаа, мөн хөл хорио тогтоох үеүдэд албан үүргээ гүйцэтгэсэн төрийн албан хаагчдад хандив тусламж үзүүлэх ажлыг зохион байгуулав.

Салбарын ажилтнуудыг оролцуулсан онлайн сургалт, уулзалт, туршлага солилцох арга хэмжээ болон мэдээ мэдээлэл түгээх, ажлын гүйцэтгэлийг дүгнэх уулзалтуудыг тогтмолжуулж ажиллаа.



ЦАХИМ ШИЛЖИЛТ

Иргэд, байгууллагын жилээс жилд нэмэгдсээр байгаа цахим сувгийн хэрэглээ цар тахлын нөлөөгөөр улам бүр хурдсаж байна. Тэнгэр Даатгал ХХК нь даатгалын үйлчилгээгээ цахимжуулах алхмыг 2017 оноос эрчимтэй эхлүүлсэн бөгөөд онлайн даатгалын үйлчилгээ авах боломжтой www.edaatgal.mn вэб платформыг 2018 онд зах зээлд танилцуулсан. Мөн 2019 оноос 18001889 тусгай дугаар болон иргэдийн түгээмэл ашигладаг сошиал сувгуудаар дамжуулан зайнаас үйлчлэх шийдлүүдийг үйл ажиллагаандаа амжилттай нэвтрүүлж эхэлсэн. Эдгээр туршлага дээрээ суурилан цахим шилжилтийг улам бүр эрчимжүүлж 2020 онд хэд хэдэн төсөл хэрэгжүүллээ. Үүнд:

- Ухаалаг гар утасны Edaatgal аппликэйшн хөгжүүлж 2020 оны 10 сард нээлтээ хийсэн ба оны эцэст 17,000 хэрэглэгчидтэй боллоо. Энэхүү аппликэйшнээрээ харилцагч нарт тулгардаг дараах асуудлуудыг шийдвэрлэсэн.
- Монгол Улсын өнцөг булан бүрд ажиллаж, амьдардаг иргэн бүр байгаа газраасаа, хэзээ хүссэн цагтаа гар утсаараа даатгалын үйлчилгээ авах боломжтой болсон;
- Даатгалын тохиолдолд ослоо зургаар баримтжуулан аппликэйшнээрээ дамжуулан илгээгээд, цагдаа, даатгал хүлээж цаг алдалгүй замаа чөлөөлөх боломжтой;
- Нөхөн төлбөрийн хүсэлт материалаа илгээх, шийдвэрлэлтийн явцыг нь хянах боломжтой;
- Даатгалын хугацаа дуусахыг урьдчилан сануулах мэдэгдэл болон даатгалын талаар өөрт хэрэгтэй мэдээ, мэдээлэл хүлээн авах.
- Мобиком корпорацын Монпэй аппликэйшн дотор Edaatgal мини аппликэйшн байршуулсан нь илүү олон харилцагч нарт ойртож, хүртээмж нь нэмэгдсэн;
- Даатгалын болон төрийн үйлчилгээнүүдийг нэг дороос авах боломжтой “Тэнгэр Даатгал Киоск”-ыг Асимон брокерс ХХК-тай хамтран нэвтрүүлж Улаанбаатар хотын хүн ам төвлөрсөн 5 байршилд ажиллуулж байгаа нь иргэдэд ойртсон бас нэг хялбар суваг болж нэмэгдсэн;
- Мөн компанийн дотоод процессуудаа автоматжуулах төслийн хүрээнд Оффис365 системийн шийдлүүдийг үйл ажиллагаандаа бүрэн ашиглаж нөхөн төлбөрийн шийдвэр гаргах, батлах процессыг цахимжуулж, харилцагчдынхаа нөхөн төлбөрийн түүх, бичиг баримтууд, хороодын хурлын материал, бизнесийн түншүүдтэй байгуулсан гэрээ хэлцэл, дотоод журам дүрэм, хууль эрх зүйн актуудын цахим сан бий болгосон зэрэг нь ажлын уялдаа холбоо үр ашиг сайжрах, харилцагчийн үйлчилгээний хурд нэмэгдэхэд нөлөөлж байна.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Эрсдэл хүлээн авах нь даатгалын бизнесийн үйл ажиллагааны томоохон үүрэг хэдий ч үнэн хэрэгтээ, даатгалын компаниуд эрсдэлийг хүлээн авахдаа урьдчилан тодорхойлсон эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээнд байгаа эсэхийг хянаж, холбогдох бодлогын дагуу шийдвэр гарган ажилладаг. Тэнгэр Даатгал ХХК-ийн эрсдэлийн удирдлагын нэгж нь энэхүү зарчмыг бодит байдалд хэвшүүлэхийн төлөө ажиллаж байна. Эрсдэлийн удирдлагыг өдөр тутмын бизнесийн үйл ажиллагаа, стратеги төлөвлөлтдөө хэвшүүлснээр тогтвортой өрсөлдөх чадварыг бий болгох юм.

Бид харилцагчаа хамгаалах бодлогыг нэн тэргүүнд баримтлан ажилладаг. Үүний хүрээнд харилцагчдын үйл ажиллагааны онцлог, шаардлага, хэрэгцээнд тулгуурласан даатгалын бүтээгдэхүүн, хамгаалалтыг санал болгохоос гадна тэдгээрийн эрсдэлийн үнэлгээг хийж, эрсдэлийг удирдах зөвлөмжүүдийг хүргүүлэх зэрэг арга хэмжээг авч ажилласан байна. Мөн харилцагчийн өмнө хүлээсэн үүргээ цаг ямагт биелүүлэхийн тулд хүрэлцээтэй буюу зохистой хэмжээний нөөц сан байгуулах нь Тэнгэр даатгал ХХК-ийн хувьд өндөр ач холбогдолтой бөгөөд эрх бүхий байгууллагуудын зүгээс хүрэлцээтэй гэсэн үнэлгээг тогтмол авсаар ирлээ. Үүний илрэл нь бид даатгалын салбартаа манлайлан дэлхийн хамгийн том аудитын компаниудтай сүүлийн 11 жилийн хугацаанд хамтран ажиллаж санхүүгийн тайлан, нөөц сангийн хүрэлцээтэй байдалд үнэлгээ хийлгүүлэн ажилласан байна.

Зохицуулагч байгууллага болох Санхүүгийн Зохицуулах Хороо (СЗХ)-ноос хэрэгжүүлж буй Эрсдэл ба төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт (Own Risk and Solvency Assessment, ORSA)-ийг зах зээлийн тэргүүлэгчдийн нэгийн хувиар тус компани амжилттай хэрэгжүүлж байна.

“Эрсдэлийн удирдлагын тогтолцоо” нь холбогдох бодлого, журам, зааврыг зохицуулсан эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх үндсэн бичиг баримт юм. Тус тогтолцоо нь гурван шатны хамгаалалтын системд тулгуурласан. Гурван шатны хамгаалалтын системийг хэрэгжүүлснээр нийт ажилтны оролцоогоор дамжуулан эрсдэлийн удирдлагын систем өдөр тутмын бизнесийн үйл ажиллагаанд ажиллах бололцоог бүрдүүлнэ.

2020 онд Тэнгэр Даатгал ХХК нь төлөвлөгөөний дагуу Эрсдэлийн удирдлагын тогтолцоо болон Эрсдэлийн удирдлагын бодлогын бичиг баримтыг шинэчилж батлуулан ажиллалаа. Ингэснээр эрсдэлийн удирдлагыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэхэд илүү тодорхой, үр дүнтэй болсон. Эрсдэлийн удирдлагын бичиг баримтын дагуу шаардлагатай арга хэмжээг цаг тухай бүрд нь авч ажилласнаас онцолбол дараах зүйлсийг дурдаж болохоор байна.

COVID-19 цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан Гамшгийн үед ажиллах төлөвлөгөөг богино хугацаанд боловсруулан ажилласан бөгөөд цар тахлын үеийг хэвийн үйл ажиллагаа, ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй байдалд ямар нэгэн сөрөг нөлөөгүйгээр даван туулж байна.

НӨХӨН ТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА



Тайлант 2020 онд нийт 4,979 даатгалын тохиолдолд 4.1 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг ажлын 3 хоногт шийдвэрлэн олгож даатгуулагч, харилцагч нарынхаа санхүүгийн асуудалд томоохон дэмжлэг үзүүллээ. Үүнээс, давхар даатгалын компаниар 531.8 сая төгрөгийг төлүүлсэн бол Тэнгэр Даатгал компани 3.6 тэрбум төгрөгийг өөрөө хариуцан олгожээ. Нийт олгосон нөхөн төлбөрийн 21 хувийг эрүүл мэнд, гэнэтийн ослын, 65 хувийг тээврийн хэрэгсэл болон жолоочийн хариуцлагын албан журмын, 13 хувийг эд хөрөнгийн даатгалын нөхөн төлбөр тус тус эзэлж байна.

Манай компанийн хөгжүүлсэн хэрэглэхэд хялбар Edaatgal аппликейш-ээр харилцагч ослын талаарх баримт, материалыг газар дээрээс цахимаар илгээн, зохих заавар зөвлөмжийг цаг алдалгүй авах болсон нь их хотын замын хөдөлгөөнд саад учруулахгүйгээр асуудлыг шийдвэрлэж буй томоохон ач холбогдолтой юм. Түүнчлэн, харилцагч илгээсэн хүсэлтийнхээ шийдвэрлэлтийн явцыг харах болон нөхөн төлбөрийн хариуг хүлээн авах боломж бүрдсэн билээ.

Монгол улсын Засгийн газраас гамшгаас хамгаалах бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед ч Тэнгэр Даатгал компанийн нөхөн төлбөрийн үйл ажиллагаа цахимаар явагдаж, даатгуулагчдынхаа өмнө хүлээсэн үүргээ тасралтгүй ханган ажиллаж байна.

Олгосон нөхөн төлбөр



4.1 тэрбум

Тээврийн хэрэгсэл,
Жолоочийн хариуцлагын даатгал



65%

Эрүүл мэнд,
гэнэтийн ослын даатгал



21%

Эд хөрөнгийн даатгал



13%

ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ

ЕРДИЙН ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ

2020 онд Монгол улсын эдийн засаг 5.3 хувиар буурсан хэдий ч Даатгалын салбарын нийт хөрөнгийн дүн 14 хувиар өссөн жил байлаа. Салбарын нийт хураамжийн орлого 6.5 тэрбум төгрөгөөр өссөн нь Хөрөнгийн даатгалын хэлбэрийн хураамжийн орлого 6.3 тэрбум төгрөгөөр өссөнтэй холбоотой. Тэнгэр даатгалын хувьд Давхар даатгалд байршуулсан Хариуцлагын даатгалын хэлбэрийн хураамжийн дүн 0.8 тэрбум төгрөгөөр өссөн байна.

НИЙТ ХУРААМЖИЙН ОРЛОГО

Тайлант хугацаанд ердийн даатгалын компаниуд сайн дурын 465,804 болон албан журмын даатгалын 635,558 даатгалын гэрээ байгуулж, нийт 200.0 тэрбум төгрөгийн хураамжийн орлогыг төвлөрүүлсэн байна. Сүүлийн 5 жилийн даатгалын нийт хураамжийн дундаж өсөлт 12.8 хувь байсан хэдий ч 2020 онд эдийн засгийн нөхцөл байдал, цар тахалтай холбоотойгоор нийт хураамжийн өсөлт 2.5 хувь болж буурлаа.


НӨХӨН ТӨЛБӨР

Тайлант хугацаанд нийт 59.3 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг даатгуулагчид олгосон ба өнгөрсөн онтой харьцуулахад нөхөн төлбөрийн дүн 7.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Нийт нөхөн төлбөрийн 90.8 хувь нь даатгалын 4 хэлбэрийн нөхөн төлбөрөөс бүрдэж байгаагийн 29 хувийг жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын, 29.1 хувийг авто тээврийн хэрэгслийн даатгалын, 17.6 хувийг гэнэтийн осол, эмчилгээний даатгалын, 14.4 хувийг хөрөнгийн даатгалын нөхөн төлбөр тус тус эзэлж байна.

АШИГТ АЖИЛЛАГАА


2020 онд ердийн даатгалын компаниудын нийт цэвэр ашгийн дүн 17.6 тэрбум төгрөг байх ба энэхүү дүн өмнөх онтой харьцуулахад 5.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

НИЙТ ХУРААМЖ




■ Тэнгэр Даатгал
□ Бусад

НИЙТ ХӨРӨНГӨ




■ Тэнгэр Даатгал
□ Бусад

ЦЭВЭР АШИГ




■ Тэнгэр Даатгал
□ Бусад

ЭЗДИЙН ӨМЧ




■ Тэнгэр Даатгал
□ Бусад

НӨӨЦ САН



■ Тэнгэр Даатгал
□ Бусад

ЦЭВЭР НӨХӨН ТӨЛБӨРИЙН
ЗАРДАЛ



■ Тэнгэр Даатгал
□ Бусад

Эх сурвалж: Монголын даатгалын холбоо

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА



Төрөлхийн зүрхний гажиг нь дэлхийд 100 төрөлт тутамд 1 тохиолддог. Монгол улсад жилдээ дунджаар 1,000 зүрхний төрөлхийн гажигтай хүүхэд төрдөг ба 20-30% нь зайлшгүй хагалгаанд орох шаардлагатай байдаг. Харин “Зүрх Мартахгүй” төсөл нь хүүхдийн зүрхний төрөлхийн гажгийг үнэ төлбөргүй эмчлэх санаачлага гарган ажиллаж, 2020 онд нийт 80 гаруй хүүхдэд амжилттай хагалгаа хийсэн байна. Тэнгэр Даатгал компани нийгмийн хариуцлагын хүрээнд энэхүү ажлыг дэмжиж “Зүрх Мартахгүй” төслийн хамт олонд 20 сая төгрөг хандивлалаа.



Цар тахалтай тэмцэж буй энэ үед тэргүүн эгнээнд ажиллаж байгаа тээврийн цагдаагийн албаны хамт олонд амны хаалт, гар ариутгагч ариутгагч хамгаалалтын хувцас зэргийг хандивлалаа. Түүнчлэн Тэнгэр Даатгал компани орон нутгийн салбаруудаараа дамжуулан Аймгуудын Тээврийн Цагдаагийн Албанд хүргүүлсэн.

УДИРДЛАГЫН БАГ



ЖАРГАЛСАЙХАНЫ МӨНХСАЙХАН

Гүйцэтгэх захирал

Ж. Мөнхсайхан нь 2020 оны 1 сараас эхлэн Тэнгэр Даатгал компанийн гүйцэтгэх захирлаар томилогдон ажиллаж байна. Жаргалсайханы Мөнхсайхан нь 2014 оны 10-р сараас 2015 оны 12 сар хүртэл Тэнгэр Даатгал ХХК-д Гүйцэтгэх Захирлын орлогчоор ажиллаж байсан туршлагатай. Тэрээр 2010-2014 оны хооронд Тэнгэр Санхүүгийн Нэгдэл, Олон Улсын Санхүүгийн Корпораци (IFC)-аас хөрөнгө оруулсан БНХАУ-ын Шинжаан Уйгарын Өөртөө Засах Автономит Улсын нийслэл Үрэмч хот дахь ТианРонг Бичил Санхүүгийн Байгууллагад төслийн зөвлөх, Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан.

Ж.Мөнхсайхан нь 2000 оноос 2010 хүртэл ХасБанкинд Салбарын менежер, Салбарын Үйл Ажиллагааны Газрын захирал, Зээлийн Хэлтсийн захирал, Картын Төвийн захирал, Маркетингийн Газрын захирал, Бүтээгдэхүүн Хөгжлийн Хэлтсийн захирал, Хэрэглээний Банкны Хэлтсийн захирлаар ажиллаж байсан туршлагатай. Ж.Мөнхсайхан нь ХҮДС-ийг санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр бизнесийн удирдлагын бакалавр, АНУ-ын Вашингтон хотын Страйер Их сургуулийг төслийн удирдлагын чиглэлээр бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй төгссөн.



БАТХУЯГИЙН ОЮУН

Эрсдэл хариуцсан захирал

Б. Оюун нь Тэнгэр Даатгал ХХК-ийн Эрсдэл хариуцсан захирлаар 2020 оны 2-р сараас эхлэн томилогдон ажиллаж байна. Тэрээр даатгалын салбарт 10 жил ажилласан туршлагатай бөгөөд ажлын гараагаа Тэнгэр Даатгал ХХК-д Актуарчаас эхлүүлж, Бизнес хөгжүүлэлтийн хэлтсийн захирал, Эрсдэлийн удирдлагын хэлтсийн захирал зэрэг албан тушаалуудыг тус тус хашиж байсан. Түүнчлэн, Монголын Актуарчдын Нийгэмлэгийн гүйцэтгэх захирлын үүргийг давхар хариуцаж, даатгалын актуарын хөгжилд хувь

нэмрээ оруулахаар ажилладаг билээ. Б.Оюун нь ОХУ-ын М.В.Ломоносовын нэрэмжит Москвагийн их сургуулийг математикч, системийн программист мэргэжлээр төгссөн ба магистрын зэргийг Австрали улсын Мельбурны их сургуульд Актуарын шинжлэх ухааны чиглэлээр хамгаалжээ.



ЖУКОВЫН БААТАРБОЛД

Иргэдийн даатгал хариуцсан захирал

Ж.Баатарболд нь 2020 оны 1 дүгээр сард Тэнгэр Даатгал ХХК-д Иргэдийн даатгал хариуцсан захирлаар томилогдсон. Тэрээр 2004 онд ХасБанкинд Жижиг дунд бизнесийн зээлийн мэргэжилтнээр ажлын гараа эхлүүлж тус банкинд Салбарын захирал, Бүсийн захирал, Салбарын удирдлагын хэлтсийн захирлаар 2020 оны 1 сар хүртэл тус тус ажиллаж, иргэдийн банкны чиглэлээр олон өөрчлөлт, шинэчлэлтийн төслүүдийг амжилттай удирдсан туршлагатай. Мөн ХБНГУ-ын Шпаркассэ банкны Монгол дахь сан, Монголбанк, Монголын Банкны Холбооноос хамтран хэрэгжүүлж буй төслийн “Харилцагчид

зөвлөх банкны мэргэжилтний сургалт”-ын мастер сургагч багшаар ажилладаг. Жуковын Баатарболд нь Санхүү эдийн засгийн дээд сургуулийг банкны удирдлага мэргэжлээр бизнесийн удирдлагын бакалавр, Люксембургийн Их Гүнт улсын Люксембургийн их сургуулийг банк санхүүгийн мэргэжлээр магистрын зэрэгтэй төгссөн.



ДАМДИНХОРОЛЫН ТЭНГИС


Байгууллагын даатгал хариуцсан захирал

Д.Тэнгис нь 2020 оны 6 сараас эхлэн Тэнгэр Даатгал компанийн Байгууллагын даатгал хариуцсан захирлаар томилогдон ажиллаж байна.

Дамдинхоролын Тэнгис нь 2013-2020 оны хооронд Тэнгэр Санхүүгийн Нэгдэл, Олон Улсын Санхүүгийн Корпораци (IFC)-аас хөрөнгө оруулсан БНХАУ-ын Шинжаан Уйгарын Өөртөө Засах Орны нийслэл Өрөмч хот дахь ТианРонг Бичил Санхүүгийн Байгууллагад Үйл ажиллагаа хариуцсан болон Гүйцэтгэх захирлаар, Сондуулт-ЭГ ХХК-д 2010-2013 Ерөнхий


Менежерээр, 2006 - 2010 оны хооронд ХасБанкинд Теллер, Худалдааны Санхүүжилтийн мэргэжилтнээр тус тус ажиллаж байсан туршлагатай. Тэрээр Ляонингийн Их сургуулийг Хятад хэл судлал, СЭЗДС-ийг санхүү, Нягтлан бодох бүртгэл Бизнесийн Удирдлагын бакалавр, БНХАУ Даляний далайн хэргийн их сургуулийг ОУ-ын худалдаа, Эдийн засгийн ухааны магистрын зэрэгтэй тус тус төгссөн.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД



ТЭНГЭР САНХҮҮГИЙН НЭГДЛИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

ТСН ХХК нь олон улсын санхүүгийн байгууллагууд, дотоодын болон гадаадын нэр хүндтэй компаниуд, хөрөнгө оруулалтын сангууд, төрийн бус байгууллагууд болон хувь хүмүүсээс бүрдсэн хувьцаа эзэмшигчидтэй ба одоогоор Монгол Улсын банк, санхүүгийн салбарт олон талын хувьцаа эзэмшигчдийн бүтэцтэй цорын ганц компани юм.

	Монголын Алт (МАК) Корпораци	20.00%
	Олон улсын санхүүгийн корпораци (IFC)	17.17%
	ОРИКС Корпораци	16.81%
	ЕСБХБ (EBRD) 12.91%	12.91%
	Канадын Үндэсний Банк (NBC)	10.52%
	Ронок Партнерз	10.15%
	Монголиа Оппортунитиз Сан	6.63%
	Триодос Фэр Шэр Фанд	3.73%
	Нээлттэй Нийгэм Форум	1.59%
	Улаанбаатар Ротари Клуб	0.30%
	Магваны Болдоо	0.10%
	Чулууны Ганболд	0.09%

ХЯНАН НИЙЦҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА



Компанийн засаглал, бизнесийн үйл ажиллагааны амин чухал хэсэг нь хууль тогтоомж, дүрэм журмыг хэрэгжүүлэх явдал билээ. Манай компани нь Монгол Улсын хууль тогтоомжид нийцсэн комплаенсийн журам боловсруулан баталж, компанийн бүх түвшинд мөрдүүлэн бэхжүүлэх, үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор комплаенсийн асуудал хариуцсан ажилтан буюу Хянан нийцүүлэлтийн мэргэжилтний ажлын байрыг бий болгож комплаенсийн үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Мөн оновчтой комплаенсын хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүднээс эрсдэлийн хамгаалалтын 3 үе шат бүхий чиг үүргийг нийт компанийн түвшинд хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд Эрсдэлээс урьдчилан сэргийлэхээс гадна Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр анхаарч ажилладаг. Энэ утгаараа Санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэгч олон улсын байгууллага болох ФАТФ-аас явуулсан Монгол Улсыг саарал жагсаалтаас гаргах сүүлийн шатны газар дээрх хяналт шалгалтад манай компани нь даатгалын салбарт үйл ажиллагаа эрхлэгч нийт байгууллагуудыг төлөөлөн амжилттай оролцлоо.

Комплаенсийн үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо, Монголын даатгалын холбоо, Банк санхүүгийн академиас хамтран зохион байгуулсан “Комплаенс ба ёс зүй онлайн сургалт”-д менежментийн баг, даатгалын менежер, мэргэжилтэн, салбарын захирал, нөхөн төлбөрийн менежер, хянан нийцүүлэлтийн мэргэжилтэн зэрэг нийт ажиллагсдаа хамруулж, сургалтанд хамрагдсан ажиллагсад сертификатаа гардан авсан.

Түүнчлэн компанийн дотооддоо нийт ажилтнуудад Монгол Улсын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаатай холбоотой сургалтуудыг тогтмол зохион байгуулж, мэдээлэл зөвлөмж, гарын авлагыг бэлтгэн хүргүүлж ажилладаг.

Харилцагчийг таних, сэжигтэй гүйлгээг илрүүлэх чиглэлээр дотоод хяналт шалгалтыг тогтмол хэрэгжүүлж, холбогдох хуульд заасны дагуу харилцагчийн мэдээлэл, материалын бүрдүүлбэрд хяналт шалгалтыг хийж, шаардлагатай нэмэлт мэдээллийг харилцагчаас авах ажлууд хийгдсэн байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



ГҮМЭНЖАВЫН ЦЭВЭГЖАВ

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга

Гүмэнжавын Цэвэгжав нь 2019 оны 5 дугаар сарын 8-ны өдрөөс ХасБанкны Гүйцэтгэх захирлаар томилогдсон бөгөөд үүнээс өмнө 2011-2013 онуудад ХасБанк болон ТэнГэр Санхүүгийн Нэгдлийн (ТСН) Санхүү эрхэлсэн захирлаар, 2015 оны 9 сараас эхлэн ХасБанкны Иргэдийн банк хариуцсан захирал, Ерөнхий захирлаар ажиллаж байсан. Мөн Г.Цэвэгжав нь 2013 оны 3 дугаар сараас 2019 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийг хүртэл ХасЛизинг ХХК-ийн Гүйцэтгэх захирал, 2014-2016 онуудад Тэнгэр Даатгал ХХК-ийн ТУЗ-ийн даргын албыг тус тус хашиж байсан. Тэрээр өмнө нь АНУ-ын Сан Франциско хотод 2008-2010 онуудад Restoration Hardware компанид хөрөнгө зохицуулалтын менежерээр ажиллахдаа тус компанийн хөрөнгө зохицуулалт, эрсдэлийн удирдлагыг хариуцаж байв. Түүнчлэн Сан Франциско хотод байрладаг Bluefin Associates (PlumSlice) компанид санхүү эрхэлсэн захирлаар, АНУ-ын Дэнвэр хотод байрлах Wagner Equipment компанид 2004-2008 онуудад хөрөнгө зохицуулалтын шинжээч болон олон улсын нягтлан бодогчоор тус тус ажилласан туршлагатай. Г.Цэвэгжав нь АНУ-ын Колорадогийн Их Сургуулийг олон улсын бизнес ба мэдээллийн системийн чиглэлээр бизнесийн удирдлагын бакалавр, АНУ-ын Режис Их Сургуулийг санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй төгссөн.



ГАНЗОРИГИЙН ЭРДЭНЭБАЯР

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн

Г.Эрдэнэбаяр нь 2013 оны 1 дүгээр сараас ХасБанкны Санхүү хариуцсан захирлаар ажиллаж байна. Тэрээр ажлын гараагаа 2005 онд ХасБанкны эрсдэлийн менежерээр эхэлсэн бөгөөд 2008 онд Эрсдэлийн нэгдсэн удирдлагын газрын захирал, 2012 онд Санхүүгийн удирдлагын газрын захирлаар ажиллаж байсан. Г.Эрдэнэбаяр нь 2002-2006 онд Санхүү эдийн засгийн дээд сургуулийг бизнесийн удирдлагын бакалавр, 2010-2012 онд Японы Олон улсын их сургуульд бизнесийн удирдлагын магистрын зэргийг санхүүгийн чиглэлээр тус тус хамгаалсан.



ЖАРГАЛСАЙХАНЫ МӨНХСАЙХАН

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн

Ж. Мөнхсайхан нь 2020 оны 1 сараас эхлэн Тэнгэр Даатгал компанийн гүйцэтгэх захирлаар томилогдон ажиллаж байна. Жаргалсайханы Мөнхсайхан нь 2014 оны 10-р сараас 2015 оны 12 сар хүртэл Тэнгэр Даатгал ХХК-д Гүйцэтгэх Захирлын орлогчоор ажиллаж байсан туршлагатай. Тэрээр 2010-2014 оны хооронд Тэнгэр Санхүүгийн Нэгдэл, Олон Улсын Санхүүгийн Корпораци (IFC)-аас хөрөнгө оруулсан БНХАУ-ын Шинжаан Уйгарын Өөртөө Засах Автономит Улсын нийслэл Үрэмч хот дахь ТианРонг Бичил Санхүүгийн Байгууллагад төслийн зөвлөх, Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан. Ж.Мөнхсайхан нь 2000 оноос 2010 хүртэл ХасБанкинд Салбарын менежер, Салбарын Үйл Ажиллагааны Газрын захирал, Зээлийн Хэлтсийн захирал, Картын Төвийн захирал, Маркетингийн Газрын захирал, Бүтээгдэхүүн Хөгжлийн Хэлтсийн

захирал, Хэрэглээний Банкны Хэлтсийн захирлаар ажиллаж байсан туршлагатай. Ж.Мөнхсайхан нь ХҮДС-ийг санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр бизнесийн удирдлагын бакалавр, АНУ-ын Вашингтон хотын Страйер Их сургуулийг төслийн удирдлагын чиглэлээр бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй төгссөн.



ЭРИК ВЕРСАВЕЛ

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн

Эрик Версавел нь Бельги улсын иргэншилтэй ба Антверп-н Их Сургуульд Хуулийн Магистарын зэргийг хамгаалжээ. Тэрээр 1983 онд өөрийн карьерийг Брюсселс Ламберт Банкнаас эхэлж байсан ба 1989 онд Бельгээс ББЛ Лондон, Сөүл болон Жакарта-д ажиллахаар явж байв. Тэрээр ING-руу 1998 оны нэгтгэлийн дараа шилжсэн ба ПТ Ай ING Индонез-д Захирлаар орж байжээ. 2000 онд тэрээр ING Шанхай-н Салбар ба Хятадыг хариуцсан гүйцэтгэх захирал, 2004 онд Солонгосыг хариуцсан гүйцэтгэх захиралаар ажилласан ба 2009 онд Европ руу буцан Азийг Хариуцсан захиралаар ажилласан. 2011 онд тэрээр Украин улсыг хариуцсан гүйцэтгэх захирал болсон ба ING Банк ПЖЭсСи-н ТУЗ-н Даргаар ажиллаж байв.

5 жилийн турших улс төр, эдийн засаг, санхүүгийн хямралын дараа тэрээр Ази руу буцаж Монгол Дахь ING Банкны Суурин Төлөөлөгч болжээ. Эрик хөгжин буй болон хямралд буй зах зээлд ажиллаж туршлага хуримтлуулсан нэгэн бөгөөд хэд хэдэн олон улс хоорондын бизнесийг удирдаж олон улсын харилцагч нартай харилцаа холбоо тогтоон ажиллаж байсан. Тэрээр өөрийн карьерийн хугацаанд ING-д болон иргэний нийгэмд цөөнгүй удирдах албан тушаалыг хашиж байв. Жишээ хэлвээс, Хятад дахь Бенелуксийн Худалдааны Танхимын (БенЧам)-н Дарга, Украин дахь Гадаадын Банкнуудын Дарга байсан ба 2017 оны 3 дугаар сард тэрээр Монгол дахь Америкийн Худалдааны Танхимд (АмЧам) Санхүүгийн Хороог үүсгэн байгуулсан.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН



Тэнгэр Даатгал ХХК-ийн Хувьцаа эзэмшигч танаа:

Санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дүгнэлт

Бид Тэнгэр Даатгал ХХК (цаашид “Компани” гэх)-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн байдлын тайлан, дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бид, Компанийн 2020 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид “СТОУС” гэх)-ын дагуу үнэн, шударгаар илэрхийлж байна гэж дүгнэж байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (цаашид “АОУС” гэх)-ын дагуу гүйцэтгэсэн болно. Уг стандартуудын дагуу бидний хүлээх үүргийг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг хэсэгт тусгасан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (цаашид “НБЁЗОУСЗ-ын дүрэм” гэх)-ийн дагуу Компаниас хараат бус ба НБЁЗОУСЗ-ын дүрмийн дагуу бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

Бусад мэдээлэл

Компанийн удирдлага бусад мэдээллийн талаар үүрэг хүлээнэ. Бусад мэдээлэлд захирлууд ба гүйцэтгэх удирдлагын мэдэгдэлд агуулагдсан мэдээллүүд орох бөгөөд санхүүгийн тайлан болон энэхүү аудиторын дүгнэлт орохгүй.

Энэхүү санхүүгийн тайланд өгсөн манай аудиторын дүгнэлт нь бусад мэдээллийг хамраагүй бөгөөд бид бусад мэдээлэлд ямар нэгэн дүгнэлт өгөхгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй бөгөөд бусад мэдээлэл нь санхүүгийн тайлан эсвэл аудитын ажлын хүрээнд олж мэдсэн мэдээллээс материаллагаар зөрүүтэй эсвэл зөрүүтэй мэт харагдаж байгаа эсэхийг авч үзэх ёстой. Хэрэв бид хийсэн ажил дээрээ үндэслэн бусад мэдээлэл нь материаллаг алдаатай байна гэж үзвэл бодит мэдээллийг тайлагнах үүрэгтэй. Үүнтэй холбоотойгоор ямар нэгэн тайлагнах зүйл байгаагүй болно.

Санхүүгийн Тайлантай холбоотой Удирдлага болон Засаглах Эрх Бүхий Этгээдийн Үүрэг

Удирдлага нь санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу бэлтгэн шударгаар илэрхийлэх, эдгээр санхүүгийн тайланг алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсэлтэй материаллаг хэмжээний алдаагүйгээр бэлтгэж, шударгаар илэрхийлэхийн тулд удирдлагаас шаардлагатай гэж тогтоосон дотоод хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ Компанийг татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоох, эсвэл үүнээс өөр боломжит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд Удирдлага Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжийг үнэлэх, тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг ашиглан санхүүгийн тайлангаа бэлтгэх үүрэгтэй.

Засаглах эрх бүхий этгээд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг

Санхүүгийн тайлан нь бүхэлдээ алдаа эсвэл санаатай зальт үйлдлийн улмаас материаллаг хэмжээний алдаагүй илэрхийлэгдсэн эсэх талаар ул үндэслэлтэй нотолгоо олж авах болон бидний дүгнэлтийг агуулсан аудиторын тайланг гарган гэрээт ажлын гэрээнд заасан эрх бүхий этгээд болох та бүхэнд хүргүүлэх нь бидний зорилго юм. Энэхүү тайлангийн агуулгын хүрээнд бид аливаа бусад этгээдийн өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүй болно. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудит нь байнга материаллаг хэмжээний алдааг илрүүлдэг гэсэн баталгаа болохгүй. Алдаатай илэрхийлэл нь алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсч болох ба дангаараа эсвэл нийтдээ эдгээр санхүүгийн тайланд үндэслэн шийдвэр гаргах санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үздэг.

АОУС-ын дагуу аудитын нэг хэсэг болгож, бид аудитын туршид мэргэжлийн үнэлэмж болон үл итгэх үзлийг баримталсан болно. Мөн түүнчлэн:

- Залилан болон алдаанаас үүсч болохуйц санхүүгийн тайлангийн материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлон үнэлж уг эрсдэлүүдэд тохирох аудитын горимуудыг боловсруулан гүйцэтгэж, аудитын дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай болон зохистой аудитын баримт, нотолгоог олж авна. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг. Учир нь залилан нь үгсэн тохирох, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, худал батламж гаргах болон дотоод хяналтыг зөрчих зэрэг явдлуудаас үүссэн байх магадлалтай байдаг.
- Бид Компанийн дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус зөвхөн нөхцөл байдалд тохирох аудитын горимуудыг сонгох зорилгоор дотоод хяналтуудыг судалдаг.
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын зохистой байдал болон удирдлагуудын бэлтгэсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон түүнтэй холбоотой тодруулгуудын бодитой байдлыг үнэлдэг.
- Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадварт мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал болон нөхцөл байдал үүссэн эсэхийг баримт нотолгоонд үндэслэн тодорхойлж, удирдлага нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг зохистой хэрэглэсэн эсэхийг дүгнэдэг. Хэрэв бид материаллаг тодорхой бус байдал үүссэн байна гэж үзвэл санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг аудиторын дүгнэлтэнд тусгаж анхааруулах, мөн тэдгээр тодруулгууд нь зохистой биш гэж үзсэн тохиолдолд дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай байдаг. Бид дүгнэлтээ аудиторын тайлангийн өдөр хүртэлх олж авсан аудитын нотлох баримтан дээр үндэслэн гаргадаг. Тиймээс ирээдүйд болох үйл явдал эсвэл нөхцөл байдал нь Компани үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэхэд саад учруулж болох юм.
- Санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг бүхэл нь үнэлдэг ба ажил гүйлгээ, үйл явдлуудыг санхүүгийн тайланд үнэн зөв тодруулах шаардлагыг хангахуйц байдлаар толилуулсан эсэхийг үнэлдэг.

Аудитор нь засаглах эрх бүхий этгээдтэй зөвхөн аудитын ажлын цар хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад илэрсэн ач холбогдол бүхий асуудлуудаар холбогддог ба үндэ аудитын үеэр аудиторын илрүүлсэн дотоод хяналтын мэдэгдэхүйц алдаа болон дутагдал орно.



Ш.Норжинбат
Захирал, МНБ

Делоитт Онч Аудит ХХК
Монгол улс, Улаанбаатар хот
2021 оны 6 сарын 28

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК
 САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
 2020 ОНЫ 12 САРЫН 31
 (МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

	2020	2019
ХӨРӨНГӨ		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,122,084	1,500,011
Хугацаат хадгаламж	19,421,764	18,128,134
Репо хэлцэл		1,302,422
Дансны ба бусад авлага	1,874,489	1,001,364
Орлогын албан татварын авлага	-	23,752
Даатгалын гэрээний хойшлогдсон зардал	471,302	746,209
Давхар даатгагчийн орлогод тооцоогүй нөөц	1,977,341	2,961,995
Урьдчилж төлсөн зардал	164,883	135,865
Бараа материал	62,107	85,948
Хойшлогдсон татварын хөрөнгө	51,607	15,000
Үндсэн хөрөнгө	1,366,897	1,243,827
Биет бус хөрөнгө	149,272	124,391
Нийт хөрөнгө	26,661,746	27,268,918
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ		
Өр төлбөр		
Даатгалын гэрээний нөөц сангууд	11,762,193	13,851,541
Дансны ба бусад өглөг	2,536,080	2,173,772
Санхүүгийн дериватив	139,404	224,269
Орлогын албан татварын өглөг	109,331	-
Нийт өр төлбөр	14,547,008	16,249,582
Эзэмшигчийн өмч		
Хувьцаат капитал	5,000,000	5,000,000
Нэмж төлөгдсөн капитал	130,000	130,000
Зохицуулагчийн нөөц сан	1,388,027	1,388,027
Хуримтлагдсан ашиг	5,596,711	4,501,309
	12,114,738	11,019,336
Нийт өр төлбөр ба эзэмшигчийн өмч	26,661,746	27,268,918

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК
ИЖ БҮРЭН ОРЛОГЫН ТАЙЛАН
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2020 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

	2020	2019
Орлогод тооцсон хураамж		
Даатгалын нийт орлогод тооцсон хураамж	17,283,137	16,427,707
Давхар даатгагчид ногдох хураамж	(8,033,399)	(6,392,471)
Орлогод тооцсон цэвэр хураамж	9,249,738	10,035,236
Нөхөн төлбөрийн зардал		
Нөхөн төлбөрийн зардал	(5,208,245)	(6,345,007)
Давхар даатгагчид ногдох нөхөн төлбөр	428,078	302,798
Нөхөн төлбөрийн цэвэр зардал	(4,780,167)	(6,042,209)
Даатгалын үйл ажиллагааны цэвэр орлого	4,469,571	3,993,027
Санхүүгийн ба бусад орлого	2,993,428	2,692,542
Бусад олз/гарз	24,996	(8,876)
Борлуулалт, ерөнхий ба удирдлагын зардал	(5,573,229)	(5,792,108)
Татварын өмнөх ашиг	1,914,766	884,585
Орлогын татварын зардал	(219,364)	(235,320)
Тайлант жилийн цэвэр ашиг	1,695,402	649,265
Бусад иж бүрэн орлого	-	-
Нийт иж бүрэн орлого	1,695,402	649,265



Утас: (976) - 18001889
И-мэйл: info@tengerinsurance.mn
Веб: www.tengerdaatgal.mn

Хаяг: Сити Центр 11 давхар, Б.Алтангэрэлийн
гудамж-5, Бага тойруу /14200/, Сүхбаатар
дүүрэг, 8-р хороо Ш/х-48/258